

ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ, ОРОСЫН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Ц.Батбуян**

Бид өнгөрсөн онд Монгол Улс, Холбоот Орос Улсын хооронд найрсаг харилцаа тогтоох тухай 1921 оны хэлэлцээр байгуулсаны 85 жилийг ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлсэн билээ.

Эдүгээ бид Монгол-Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэг, Найрамдлын нийгэмлэгүүдийн Монголын Эвлэлийн үндэс болсон ЗХУ-тай соёлоор харилцах Монголын нийгэмлэг байгуулагдсаны 60 жилийн ойтой золгож байна.

Дэлхийн гамшигт их дайны дараахан бий болсон энэ нийгэмлэг манай хоёр орны ард түмний найрамдал нөхөрлөл, хоёр улсын харилцааг хөгжүүлэх хэрэгт ихээхэн хувь нэмэр оруулсныг энд онцлон хэлэх нь зүйн хэрэг.

Монгол-Оросын орчин цагийн харилцаа, хамтын ажиллагаа

Орчин цагийн Монгол-Оросын харилцааны эхлэл 90-ээд оны эхээр тавигдсан гэж үзэж болно. ЗХУ задрахаас өмнө 1991 оны 2 дугаар сарын 12-нд Монгол Улсын Ерөнхий сайдыг Орос Улсад айлчлах үед “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улсын Найрамдал, сайн хөршийн хамтын ажиллагааны тухай Тунхаглал” гаргасан юм.

Уг баримт бичигт хоёр улсын “эдийн засаг, улс төрийн тогтоолцоонд болон хоёр талын хамтын ажиллагааны механизмд гарч байгаа гүнзгий өөрчлөлтүүд хоёр улсын хооронд янз бүрийн түвшинд хэлхээ холбоо, харилцан ажиллагааг эрчимжүүлэхэд шинэ боломж нээж, тус дөхөм болж байгааг харгалзан”, хамтын ажиллагааны чиглэл, механизмыг тодорхойлж байсан билээ. Удалгүй ЗХУ задарлаа.

Ийнхүү өнгөрсөн зууны 80-90-ээд оны зааг дээр дэлхий дахинд гарсан эргэлтийн чанартай үйл явдлууд, түүний дотор манай хоёр оронд өрнөсөн ардчилсан өөрчлөлтийн дүнд Монгол Улс болон ЗХУ-ын өвийг залгамжилсан ОХУ-ын хоорондын харилцаанд шинэ үе эхэлсэн юм.

Шинэ үеийн утга учир нь хоёр орон ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих ээдрээ төвөгтэй гараан дээр Монгол-Оросын харилцааг бүхэлд нь эрх тэгш, харилцан ашигтай байх, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох зарчимд тулгуурлан өөрчлөн хөгжүүлэхэд оршиж байлаа.

* Ц.Батбуян - Гадаад хэргийн яамны Хөрш орнуудын газрын дэд дарга

Энэ жил амаргүй нөхцөл байдалд эхэлсэн. Монгол Улс ч, ОХУ ч аж ахуйг эрхлэн хөтлөх төвлөрсөн захиргаадлтын аргаас зах зээлийн эдийн засагт шилжих үйл явцад хоёр талын худалдаа, хамтын ажиллагааны өмнө нь үйлчилж байсан хэвшсэн тогтолцоо явуургүй болохыг харуулж байлаа. Хамтын ажиллагаа бараг бүх салбарт зогсонги байдалд орж эхэлсэн гэж хэлж болно. Бий болсон нөхцөл байдалд улс бүр гадаад орчингоо дүгнэж, гадаад харилцааныхаа чиглэлүүдээ тодорхойлох замд гарсан хэрэг. Зарим “улс төрийн зүтгэлтэн” хоёр талын харилцааны өнгөрсөн бүхнийг харлуулах, үгүйсгэх хандлага хаа хаанаа гаргаж байсныг бид мэднэ.

1993 онд хоёр улсын хооронд Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ байгуулсан нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг шинэ нөхцөл байдалд хөгжүүлэх, харилцааны эрх зүйн үндсийг шинэчлэх үндэс суурийг тавьж өгсөн билээ. Өнгөрсөн хугацаанд хоёр улсын хооронд 120 гаруй гэрээ, хэлэлцээрийг шинээр байгуулаад байна.

1994 онд Монгол Улсын Их хурлаас баталсан Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд ОХУ-тай харилцах явдлыг гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болгон тодорхойлсон юм. Монгол Улс энэ чиг шугамыг тууштай баримталж байдаг юм.

Манай хоёр улс шилжилтийн эхэн үеийн “шок”-ноос гарч эхэлсэн хоёр зууны заагаас хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх таатай нөхцөл боломж бүрэлдэх болсныг хэлэх нь зүйтэй байх.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Монгол Улсад 2000 онд айлчлах үеэр гаргасан Улаанбаатарын Тунхаглалд Монгол, Оросын харилцааг өнөөгийн нөхцөл байдалд хөгжүүлэх үндсэн чиглэлүүдийг тодорхойлон хэрэгжүүлсэн юм.

2003 онд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр ОХУ-д албан ёсоор айлчилсан дүнгийн тухай хамтарсан албан мэдээнд “Сайн хөршийн уламжлалт түншлэлд баттай тулгуурласан Монгол, Оросын харилцааны онцгой шинж чанар түүхэн шинэ нөхцөлд хадгалагдан хөгжиж байгааг” цохон тэмдэглэж, хоёр талын харилцаа “сайн хөршийн уламжлалт түншлэл”-ийн зарчимд шилжсэн билээ.

Монгол-Оросын хамтын ажиллагааны хөгжлийн хурдац хамрах хүрээ, далайц хоёр оронд өрнөж байгаа олон талт өөрчлөлтүүд, түүний дотор эдийн засгийн өсөлтийн хэрээр түргэн өргөжиж байна гэж үзэж болохоор байна. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр өнгөрсөн оны 12 дугаар сард ОХУ-д төрийн айлчлал хийж, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинтай хийсэн яриа хэлэлцээний дүнд хоёр орны харилцааг стратегийн түншлэлийн хэмжээнд хөгжүүлэх тохиролцоонд хүрч “Москвагийн тунхаглал”-д Ерөнхийлөгч нар гарын үсэг зурсан билээ.

Стратегийн түншлэл нь манай хоёр орны харилцааны түүхэн ололтууд, өнөө болон ирээдүйн хамтын ажиллагааг зохицуулсан, гол чиглэлийг тодорхойлж өгч байгаа ойлголт гэж үзэж байна. Монгол-Оросын харилцааг чанарын ийм шинэ шатанд гаргах нөхцөл бололцоо бүрдэж байна. Хоёр улс, ард түмний харилцан сонирхол ч ийм байна. Одоо хоёр талын хамтын ажиллагааны байдлын талаар салбар тус бүрээр цөөн хэдэн зүйл хэлье.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагаа

1. Монгол Улс, ОХУ-ын худалдааны нийт эргэлт 2006 оны байдлаар 592.9 сая ам.долларт (2005 онд 426 сая ам.доллар) хүрч, импорт 547.8 сая ам.доллар, экспорт 45.1 сая ам.доллар болсон байна. Хоёр талын худалдаа нийт дүнгээр нэмэгдэж байгаа ч гэсэн Монголын экспорт сүүлийн жилүүдэд буурч байгаа нь гаалийн татвар өндөр, тээврийн зардал нэмэгдсэн тарифын бус саад тотгор зэргээс Монголын бараа Оросын зах зээлд нэвтрэх нөхцлүүд хүнд байгаад оршино.

2. Хоёр орны хооронд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхижүүлэх, энэ салбарын эрх зүйн орчинг сайжруулах, гарч буй саад бэрхшээлүүдийг арилгах талаар хоёр тал хамтран ажиллаж байна. Тухайлбал, Монгол, Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2006-2010 онд хөгжүүлэх хөтөлбөрийг 2006 оны 12 дугаар сард байгуулав. Уг хөтөлбөрт салбар тус бүрээр тодорхой зорилт дэвшүүлж байгаа. Тухайлбал, хоёр талын худалдааг 2010 он гэхэд 1 тэрбум ам.долларт хүргэх зорилт тавьж байна. Гагцхүү тохиролцож, тавьсан зорилтыг ажил хэрэг болгох талаар хоёр тал шаргуу, бүтээлчээр хамтран ажиллах ёстой.

ОХУ Дэлхийн худалдааны байгууллагад элсэхтэй холбогдуулан Хоёр талын тарифын хэлэлцээг дуусгавар болгох тухай Протоколд 2005 оны 10 дугаар сард гарын үсэг зурав. ОХУ тус байгууллагад элссэний дараа худалдааг харилцан либералчлах, тарифын бус саад бэрхшээлийг арилгах асуудлаар хийх хэлэлцээгээ үргэлжлүүлэхээр тохиролцсон.

Тарифын болон тарифын бус саад бэрхшээлийг арилгах асуудлаар Оросын талтай худалдааг либералчлах ажлын хэсэг ажиллаж байна. Энэхүү ажлын хэсгийн хүрээнд ОХУ-ын нутгаар тээвэрлэж буй манай экспортын барааны төмөр замын тээврийн тариф болон нэхмэл бүтээгдэхүүний импортын татварыг бууруулах, тарифын бус хязгаарлалтыг хөнгөвчлөх зэрэг асуудлыг хэлэлцэн, энэ чиглэлд ахиц гаргахаар тохиролцсон юм. ОХУ-ыг ДХБ-д элсэхийг хүлээхгүйгээр Монголын хөнгөн үйлдвэрийн барааг Оросын хөнгөлөлтийн ерөнхий

системд хамруулахаар тохиролцсоны дагуу Монголын тал холбогдох барааны жагсаалтыг гаргаж Оросын талд өгөөд байна.

3. ОХУ-аас Монгол Улсад 1990-2006 онд нийт бүртгэгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээ 56.3 сая ам.доллар, 2006 онд бүртгэгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээ 11.7 сая ам.доллар байна. ОХУ-аас уул уурхай /26 сая ам.доллар/, барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл /5.3 сая ам.доллар/, худалдаа нийтийн хоол /4.5 сая ам.доллар/, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл /4.2 сая ам.доллар/, банк санхүү /4.1 сая ам.доллар/ (Чингис хаан банк)-гийн салбаруудад түлхүү хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын нийт хөрөнгө оруулалтын 24.7 хувийг ОХУ-ын хөрөнгө оруулалт эзлэж байна. Барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт ч мөн адил томоохон хөрөнгө оруулагч бөгөөд энэ салбарын хөрөнгө оруулалтын 9.1 хувийг оруулсан байна. ОХУ-ын хөрөнгө оруулалттай 425 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлж байгаагаас Оросын талын 100% хөрөнгө оруулалт бүхий томоохон компани нь “Зарубежстрой”, “Бурводстрой”, “Золотой Восток-Монголия”, хамтарсан “Инкон”, “Эрдэнэтстрой” зэрэг болно.

4. Монгол, Оросын Засгийн газар хоорондын Комисс хоёр улсын худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, тулгамдсан асуудлыг цаг тухай бүрт нь хэлэлцэн шийдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ авч байна. Шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах дэд комиссын үйл ажиллагааг сэргээхээр хоёр тал тохиролцсон.

Хоёр орны хамтын ажиллагаанд “Эрдэнэт”, “Монголросцветмет” хамтарсан үйлдвэрүүд, хувь нийлүүлсэн “УБТЗ” нийгэмлэг чухал байр суурь эзэлж байна. “Монголросцветмет” хамтарсан үйлдвэрийн үйл ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2007 оны 4 дүгээр сард шинэчлэн байгуулав. “Эрдэнэт” хязгаарлагдмал хариуцлагатай компаний үйл ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр 2007 оны 3 дугаар сараас хүчин төгөлдөр болсон. Хувь нийлүүлсэн “УБТЗ”-ын хувьд хоёр талын яриа хэлэлцээ үргэлжилж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улс, ОХУ-ын субъектуудын харилцаа, хамтын ажиллагаанд мэдэгдэхүйц ахиц гарав. Монгол Улс, ОХУ-ын хоорондын худалдаанд Сибирийн тойргийн муж, улсуудын оролцоо 70 орчим хувийг эзэлж байна.

Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагаа эрхэлсэн дэд комисс Монгол, Оросын ЗГХК-ын хүрээнд байгуулагдаж, анхдугаар хуралдаанаа 1997 онд Улаан-Үд хотод хийсэн бөгөөд ээлжит VII

хуралдаан 2007 оны 4 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд ОХУ-ын Эрхүү хотноо хуралдав. Хоёр тал Монгол, Оросын бүс нутаг, хил ормын хамтын ажиллагааг хөгжүүлэх нөөц бололцоог бүрэн ашиглах, тохиолдож буй хүндрэл бэрхшээлүүдийг арилгах, хил, гаалийн албаны үйлчилгээг хөнгөн шуурхай болгох талаар дэлгэрэнгүй санал солилцож, цаашид авах арга хэмжээг тодорхойллоо.

Соёл, боловсрол, хүмүүнлэгийн харилцаа

Сүүлийн жилүүдэд соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагааны эрх зүйн үндэс шинэчлэгдэж, ахиц гарч байна. Монгол Улсын БСШУЯ, ОХУ-ын Холбооны соёл, кино урлагийн агентлагийн хооронд соёл, урлаг киноны салбарт 2006-2008 онд хамтран ажиллах хөтөлбөрийг өнгөрсөн онд байгууллаа. Өнгөрсөн онд МОНЦАМЭ, ИТАР-ТАСС агентлагийн хооронд хамтын ажиллагааны баримт бичиг байгуулав. ОХУ-ын боловсрол шинжлэх ухааны яам, Монгол улсын БСШУЯ-ны хооронд 2007-2010 онд боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах хөтөлбөр байгуулахаар хэлэлцэж байна. Монгол Улсын Эрүүл мэндийн яам, ОХУ-ын ЭМНХЯ-ны хооронд эрүүл мэнд, анагаах ухааны салбарт 2006-2010 онд хамтран ажиллах тухай протокол, Нийгмийн хамгааллын салбарт 2006-2010 онд хамтран ажиллах меморандумд гарын үсэг зурахаар ажиллаж байна.

2002 оны 10 дугаар сард Улаанбаатар, Эрдэнэт хотуудад ОХУ-ын соёлын өдрүүд, 2003 оны 7 дугаар сард ОХУ-д Монголын соёлын өдрүүд тус тус зохиогдлоо. 2003 оноос Монгол-Оросын найрамдлын сарын ажлыг олон нийтийн байгууллагуудын санаачилгаар сэргээн зохион байгуулж, энэ хүрээнд Новосибирск мужийн соёлын өдрүүд, Мосфильмын кино 7 хоног, Усть-Ордын автономит тойргийн соёлын өдрүүдийг Улаанбаатарт тус тус зохиолоо.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойтой холбогдон Монгол Улсад зохиогдсон соёл, спортын арга хэмжээнд, тухайлбал Монголч эрдэмтдийн 9 дүгээр их хурал, Дэлхийн оюутны аварга шалгаруулах бөхийн чөлөөт, сонгомол барилдааны 7 дугаар тэмцээн, Монгол туургатны чуулга уулзалтад ОХУ-ын төлөөлөгчид оролцов. Мөн Монголд болсон “Якутын өдөр”, Якутад болсон “Солнечный конь” олон улсын киноны фестивалд харилцан төлөөлөгчид оролцлоо.

ОХУ-ын их, дээд сургуулиудад гадаадын иргэдийг сургах тухай ОХУ-ын Засгийн газрын шийдвэрийн хүрээнд 2003 оноос Монголын 200 оюутан, суралцагсдыг Засгийн газар хоорондын хэлэлцээр, ОХУ-ын Ерөнхийлөгчийн тэтгэлгээр сургахаар тохиролцсон. Өнөөдрийн байдлаар ОХУ-ын 97 их, дээд сургуульд Монгол Улсаас 1367 иргэн

сурч байна. Үүнээс Монгол Улс, ОХУ-ын Засгийн газрын хооронд байгуулсан гэрээний дагуу 678 иргэн байгууллагын болон хувийн зардлаар 689 иргэн тус тус сурч байгаа болно.

90-ээд оны дундуур иргэд харилцан визтэй зорчих журамд шилжсэн явдал бүх талын солилцоо, иргэд харилцан зорчиход бэрхшээл учруулсан юм. Гэхдээ хоёр тал иргэд харилцан зорчих нөхцлийг хөнгөвчлөх, виз олгох үйлчилгээг сайжруулах, визийг үнэ төлбөргүй буюу ихээхэн хөнгөлттэйгээр олгох хүмүүсийн хүрээг өргөтгөв. Хоёр орны иргэд харилцан визгүй зорчих асуудлыг хоёр тал үргэлжлэн ярилцаж байна.

Хоёр тал Монгол-Оросын хилийн Хандгайт-Боршоо боомтыг олон улсын статустай болгох асуудлыг тохиролцож, Ханх-Мондын боомтыг мөн ийм статустай болгон гурав дахь орны жуулчдыг хүлээж авах, Хөвсгөл-Байгаль чиглэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар ажиллаж байна.

Эцэст нь тэмдэглэхэд манай хоёр орон бүс нутаг, олон улсын тавцанд идэвхитэй хамтран ажиллаж байна. Монгол-Оросын харилцаа нь Зүүн хойд Ази, Төв Азийн бүс нутгийн хэмжээнд өрнөх интеграц, олон талт хамтын ажиллагааны бүрдэл хэсэг болох ирээдүйтэй.

Анхаарал тавьсанд баярлалаа.